



“ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Р.БУД ТАНАА

ҮНДСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар хот, Төвдөлтэй дүүрэг
Баян тойруу 3, Засагын газрын IV байр
Утас: 26 (4 37) Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/456

таний _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.НАРАНЧИМЭГ



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ-ЫН

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

САГ-ын дарга, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 261885

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол Улс
Цахим хуудас: www.audit.mn

Ворлдвайд файнэнс аудит
ХХК
Захирал: Ч.Байгаль
Утас: 99091347

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Хавсралт 5:

2017 оны 3 дугаар сар

YAG-CAГ/2017/63/СТА-ТӨҮГ

АГУУЛГА

1. Аудитын хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдлын түвшин
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдлүүд , түүний үр дагавар
10. Гол онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дах заалтыг үндэслэн төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарны 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын газрын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын гаргасан холбогдох заавар, журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дугаар сарын 10 –наас 2016 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн “Ворлдвайд файнэнс аудит” ХХК аудитор Ч.Байгаль хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны 3 р улирлын тайланг 2016 оны 10 дугаар сарын 24-нд, 2016 оны жилийн санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 7-нд ирүүлсэн байна.

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд 2017 оны 02 дүгээр сарын 10-наас 2017 оны 03 дугаар сарын 10 –ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ- нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын гаргасан холбогдох заавар журмыг ашиглаж байна. Тайлант онд НББ-ийн тухай хууль 2016.01.01 шинэчлэгдсэн байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой Авто замын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Зам тээврийн яамны сайдын тушаал, Зам тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Аудитын явцад төсвийн “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, компанийн тухай хуулиудыг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Зам тээврийн салбарт эрдэм , шинжилгээ судалгаа , инновацийн үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэлд нэвтрүүлэх, салбарын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд тус төвийн эрхэм зорилго оршино.

Зам тээврийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь

- Авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлж, олон улсын жишигт хүргэн, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эрдэм шинжилгээ судалгааг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх
- Салбарын норм норматив, стандартын тогтолцоог боловсронгуй болгон, олон улсын жишигт ойртуулах
- Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын чанар, аюулгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх
- Авто замын санд олон улсын болон улсын чанартай авто замаар зорчсоны төлбөр хураах үйл ажиллагааг боловсронгуй болгох

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 –д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилохдоо гэрээ байгуулна” заасны дагуу “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай гэрээ байгуулан ажиллаж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 24 -г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн хорооны 2015 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 220 дугаар тогтоолоор өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болсон. Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй. Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын суурийг нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа тул байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн шатанд зардлын 2 хувь буюу 39,669.3 мянган төгрөгөөр тооцсон болно.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ нь 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн хорооны 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 814 тоот тогтоолоор баталсан байна.

Тус тогтоолоор 2016 оны нийт орлого 1,970,000.0 мянган төгрөгөөр, нийт зардал 1,715,524.1 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардал 25,000.0 мянган төгрөг, 171,771.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан байна.

2016 оны санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангаар борлуулалтын орлого 1,834,593.1 мянган төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 5,847.4 мянган төгрөг, ерөнхий болон удирдлагын зардал 1,934,529.7 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 32,805.2 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 39,632 мянган төгрөг тайлагнагдсан бөгөөд 165,241.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу <http://shilendans.gov.mn/org/5418> цахим хуудсанд шилэн дансны мэдээллийг оруулсан байна.

“Шилэн дансны тухай” хуулийн 6.1-д заасны дагуу 2016 оны төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний зэрэг мэдээллийг тогтмол мэдээлж байна.

Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын эрсдлийн тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ нь төрийн өмчийн хорооны шийдвэрээр балансаас балансанд үндсэн хөрөнгө шилжүүлэн авахдаа анхны өртөгөөр нь бүртгэсэн, тайлант жилийн элэгдлийн зардлыг бууруулан бүртгэсэн, үндсэн хөрөнгийг балансаас балансанд шилжүүлэхдээ үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзаар бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны орлого, үйл ажиллагааны зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. / ТАБ-СТА-В-3 /

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил тус байгууллагын нийт орлогын 45 хувь, мөнгөн хөрөнгийн 72 хувь, нийт зардлын 64 хувь, нийт хөрөнгийн 85 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлыг дараах заалтанд хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Сангийн сайдын 13/1/2180, 13-1/2183 тоот тушаалуудаар 163,835.7 мянган төгрөгний анхны өртөгтэй 107,615.3 мянган төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй 56,220.5 мянган төгрөгний үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг балансаас балансанд шилжүүлэн бүртгэхдээ 163,835.7 мянган төгрөгөөр буюу анхны өртгөөр бүртгэсэн нь НББОУС 16-д заасны дагуу “үндсэн хөрөнгийг анх удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртөгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглана бүртгэнэ. Өртгийн загварын дагуу үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь бүртгэнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй. Мөн нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-д “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” 4.1.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”-ыг дагаж мөрдөнө гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Төрийн өмчийн хорооны 236 тоот 49,887.9 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй тээврийн хэрэгслийг балансаас балансанд шилжүүлэхдээ үндсэн хөрөнгө борлуулсны алдагдал данс руу буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.1.бие даасан байх; 5.1.2. тасралтгүй байх; 5.1.3. жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4. үнэн зөв байх; 5.1.5. хэмжигдэхүйц байх; 5.1.6. зохицох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. 2016 оны үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн зөрүү болох 75,091.6 мянган төгрөгөөр тайлант жилийн элэгдлийн зардлыг бууруулж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д

“Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. 2015 оны ашгаас ТӨХ-нд 4,407.4 мянган төгрөгний ноогдол ашиг хувиарлаж, 2016 оны 11 р сарын 16 нд төрийн өмчийн хороо шилжүүлэхдээ тайлант жилийн үйл ажиллагааны бус зардлаар бүртгэж тайлант жилийн зардлыг нэмэгдүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 102/ШШ2016/00598 тоот шүүхийн шийдвэрээр Захиргаа хүний нөөцийн дарга Ц.Мөнхбат-д 2,962,2 мянган төгрөгний ажлаас үндэслэлгүй халагдсаны нөхөн олговор олгож байгууллагын үйл ажиллагааны бус зардлаар бүртгэсэн нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлж ажиллах аудитын зөвлөмж өгөх

3. ТӨХ-ны 2015 оны 4 сарын 09-ны 220 дугаар тогтоолын дагуу улсын төсөвт үйлдвэрийн газраас өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болсонтой холбогдуулан байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ”, 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах тухай менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин хөлсний бүртгэлд аудитыг бүрэн хэмжээгээр хийгээгүй тул дараагийн аудитаар цалингийн зардлыг гүйцээж мөшгин шалгах шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 237,002.1 мянган төгрөгний алдаа зөрчилд залруулга хийж, 2,962.1 мянган төгрөгний зөрчилд аудитын зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2015 оны санхүүгийн тайланд “Ворлдвайд фajnэнс аудит” ХХК-иас 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээрээс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл ажил гүйлгээнүүд холбогдох хууль, тогтоомж СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТҮГ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар-15160, Бага тойруу-3, Засгийн
газрын ҮГ байр

Менежментийн захидал

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:

- Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
- Менежер Я.Самбууням
Утас: 261885
- Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512
- Ворлдвайд файнэнс аудит ХХК
Захирал: Ч.Байгаль
Утас: 99091342
- Ахлах аудитор: З.Сумьяа
Утас: 99087154

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

- Асуудал 1.
НББ-ийн бодлогын баримт бичиг (Хуудас 3)
- Асуудал 2.
Зардал (Хуудас 4)

2017 оны 03 дугаар сар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Зам тээврийн хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан "Зам тээврийн хөгжлийн төв"ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1 . Бодлогын баримт бичиг	Тэргүүлэх ач холбогдол № 1
-----------------------------------	-------------------------------

Аудиторын ажиглалт

ТӨХ-ны 2015 оны 4 сарын 09-ны 220 дугаар тогтоолын дагуу улсын төсөвт үйлдвэрийн газраас өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болсонтой холбогдуулан байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт хийгээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9 "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалтыг мөрдөж ажиллаагүй.

Эрсдэл

- Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх
- Холбогдох хууль, дүрэм, журам, тогтоол зөрчигдөх

Аудиторын зөвлөмжүүд

Байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Асуудал 2 . Зардал	Тэргүүлэх ач холбогдол № 1
---------------------------	---------------------------------------

Аудиторын ажиглалт

2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 102/ШШ2016/00598 тоот шүүхийн шийдвэрээр Захиргаа хүний нөөцийн дарга Ц.Мөнхбат-д 2,962.2 төгрөгний ажлаас үндэслэлгүй халагдсаны нөхөн олговор олгож байгууллагын үйл ажиллагааны бус зардлаар бүртгэсэн нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Аудиторын зөвлөмжүүд

Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдэл

- Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх
- Холбогдох хууль, дүрэм, журам, тогтоол зөрчигдөх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

"ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
<u>ХӨРӨНГӨ</u>		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	186,262,522	821,320,838
Дансны авлага	465,277,429	72,680,112
Бараа материал	135,525,832	122,844,395
Эргэлтийн хөрөнгийн дүн	787,065,783	1,016,845,345
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,371,996,406	2,026,554,506
Биет бус хөрөнгө	3,098,500	2,447,000
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,375,094,906	2,029,001,506
<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>3,162,160,690</u>	<u>3,045,846,850</u>
<u>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</u>		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		-
Дансны өглөг	25,697,174	-
Татварын өр	2,613,587	695,499
Богино хугацаат өр төлбөрийн дүн	28,310,761	695,499
Урт хугацаат өр төлбөр		-
Өр төлбөрийн нийт дүн	28,310,761	695,499
Эзэмшигчдийн өмч		
Өмч: -Төрийн	1,061,770,008	1,064,339,806
Хуримтлагдсан ашиг	2,072,079,921	1,980,811,546
Тайлангийн үеийн ашиг		(165,241,672)
Өмнөх үеийн ашиг		2,146,053,218
Эзэмшигчдийн өмчийн дүн	3,133,849,929	3,045,151,352
<u>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</u>	<u>3,162,160,690</u>	<u>3,045,846,850</u>

**"ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
Борлуулалтын орлого /цэвэр/	1,751,619,512	1,834,593,122
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		-
Нийт ашиг /алдагдал/	1,751,619,512	1,834,593,122
Түрээсийн орлого		-
Хүүний орлого		5,847,448
Ногдол ашгийн орлого		-
Эрхийн шимтгэлийн орлого		-
Бусад орлого	887,164	1,869,470
Борлуулалт маркетингийн зардал		-
Ерөнхий ба удирдлагын зардал	1,630,202,559	1,934,529,713
Санхүүгийн зардал		-
Бусад зардал	32,329,781	32,805,255
Валютын ханшийн зөрүүний олз /гарз/		-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(63,838,469)	(39,632,000)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		-
Бусад ашиг /алдагдал/		-
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	26,135,867	(164,656,927)
Орлогын татварын зардал	2,613,587	584,745
Татварын дараах ашиг /алдагдал/	23,522,280	(165,241,672)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	23,522,280	(165,241,672)
Бусад дэлгэрэнгүй орлого		-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
Бусад олз /гарз/		-
Орлогын нийт дүн		-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг/ алдагдал/		-

"ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТУГ-ЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<u>2014 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</u>	<u>320,391,735</u>	<u>2,048,557,640</u>	<u>2,368,949,375</u>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
Залруулсан үлдэгдэл	320,391,735	2,048,557,640	2,368,949,375
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал		23,522,280	23,522,280
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Өмчид гарсан өөрчлөлт	741,378,273		741,378,273
Зарласан ногдол ашиг			-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
<u>2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</u>	<u>1,061,770,008</u>	<u>2,072,079,921</u>	<u>3,133,849,929</u>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		73,973,297	73,973,297
<u>Залруулсан үлдэгдэл</u>	<u>1,061,770,008</u>	<u>2,146,053,218</u>	<u>3,207,823,226</u>
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал		(165,241,672)	(165,241,672)
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Өмчид гарсан өөрчлөлт	2,569,798		2,569,798
Зарласан ногдол ашиг			-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
<u>2016 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</u>	<u>1,064,339,806</u>	<u>1,980,811,546</u>	<u>3,045,151,352</u>

"ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Аудитлагдсан дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	1,551,693,578	2,381,250,374
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,301,162,490	2,199,561,127
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,789,778	-
Татаас, санхүүжилтын орлого	188,311,971	-
Бусад мөнгөн орлого	55,429,338	181,689,247
Мөнгөн зарлага	1,363,616,055	1,743,657,397
Ажиллагчдад төлсөн	874,842,375	1,051,716,841
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	163,856,511	225,954,859
Бараа материал худалдан авахад төлсөн	100,000,274	38,412,953
Ашиглалтын зардалд төлсөн	19,045,276	22,519,413
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	27,430,714	29,605,164
Хүүний төлбөрт төлсөн		-
Татварын байгууллагад төлсөн	70,675,686	97,583,771
Даатгалын төлбөрт төлсөн	4,553,171	213,840
Бусад мөнгөн зарлага	103,212,048	277,650,555
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	188,077,522	637,592,978
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
Мөнгөн орлогын дүн		7,716,918
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		1,869,470
Хүлээн авсан хүүний орлого		5,847,448
Мөнгөн зарлагын дүн	1,815,000	10,251,580
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,815,000	10,251,580
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,815,000)	(2,534,662)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
Мөнгөн орлогын дүн		-
Мөнгөн зарлагын дүн		-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	186,262,522	635,058,315
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		186,262,522
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	186,262,522	821,320,838